



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 464

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай хамгаалалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 267,100,000.00 (хоёр зуун жаран долоон сая нэг зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 124,523,011.87 (нэг зуун хорин дөрвөн сая таван зуун хорин гурван мянга арван нэгэн төгрөг наян долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Л.Алтангэрэл, "Засгийн газрын автобааз" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлын үүрэг гүйцэтгэгч Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж (Улсын дугаар Төрийн тусгай хамгаалалтын газарт хадгалагдаж үлдэнэ), арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132005881  
23-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 09 дугаар сарын 21 өдрийн  
167 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨРИЙН  
ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ (автомашин)

д/д	Автомашины нэр, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Тоёото ландркрузер 200, (арлын дугаар- JTMHX05J704218879)	2020/2020	ш	1	267,100,000.00	124,523,011.87	142,576,988.13
Нийт дүн						124,523,011.87 (нэг зуун хорин дөрвөн сая таван зуун хорин гурван мянга арван нэгэн төгрөг наян долоон мөнгө)	142,576,988.13 (нэг зуун дөчин хоёр сая таван зуун далан зургаан мянга есөн зуун наян найман төгрөг арван гурван мөнгө)